



**"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 10-р сарын 09-ний өдөр

№ 1723 / ХТ

Улаанбаатар хот

"Мерекс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ХУД 7-р хороо Барилга Архитектур корпорацийн байр 4 давхар 419 тоотод 2023 оны 10-р сарын 09-ний өдрийн 11 цагт эхэлж 12 цагт өндөрлөв.

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангын ТУЗ-ийн дүгнэлтийн тухай
2. Ногдол ашиг хуваарилахгүй
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Д.Уянга: Сайн байцгаана уу "Мерекс" ХК-ийн саналын эрх бүхий нийт 65,005,000 ширхэг хувьцаанаас өнөөдрийн хуралд нийт 52,994,861 ширхэг хувьцаа буюу 81,5 хувьтайгаар хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр оролцож байгаа учраас энэ хурлыг хүчин төгөлдөрт тооцож болно.

Г.Бямбабаяр: Хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхлээ. Эрхэм хүндэт "Мерекс" ХК-ийн хувьцаа эзэмшигч Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нээснийг мэдэгдэе.

Өнөөдрийн хурал дараах дарааллын дагуу явагдана. Тооллогын комисс сая хурлын ирцийг танилцуулсан.

- Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах
- Асуулт хариулт
- Хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалт
- Тооллогын комисс тогтоолыг танилцуулах
- Хурлаас гарсан шийдвэр тогтоолыг танилцуулах

1. Хэлэлцэх асуудал - Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Эхлээд төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулъя.

"Мерекс" ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан өгөх дүгнэлтийн талаарх илтгэлийг компанийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулж байна.

2022 онд компанийн нийт хамт олон ТУЗ-ийн баталсан төлөвлөгөөний дагуу түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ санал санаачлагыг дэмжих, санхүүгийн хямд эх үүсвэрийг олж ашиглахад чиглэгдсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нөөц бололцоогоо дайчлан ажилласан билээ. 2021 онд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн автомат болгосон бөгөөд 2022 онд 22,000м3 борлуулах төлөвлөгөөний дагуу ажиллаж 2017-2021 оны хооронд Мөнхзолбоо захирлын үлдээсэн өр авлагаас тэрбум орчим төгрөгийг шийдвэрлэсэн болно. Ийнхүү ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулж байна. (Тайланг танилцуулав.)

2. Хэлэлцэх асуудал - Ногдол ашиг хуваарилахгүй

Компани нь сүүлийн 2-3 жилд үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд үүнээс үүдэн хөрөнгийн зах зээлд хувьцаа арилжаалагдаагүй бөгөөд үүнээс үүдэн ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гарсан болно.

3. Хэлэлцэх асуудал - ТУЗ-ийн гишүүдийг сонгох

ТУЗ-д нэр дэвшүүлэх ердийн болон хараат бус гишүүдэд санал болгож буй хүмүүсийн мэдээллийг хүргэж байна та бүхэн танилцана уу. (Танилцуулах мэдээллийг хурлын материалд тусгасан байгаа та бүхэн танилцана уу.)

ЕРДИЙН ГИШҮҮД

Гомбожавын Бямбабаяр

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1980
Боловсрол	Дээд
Мэргэжил	Нягтлан бодох бизнесийн удирдлага
Эрхэлж байсан ажил	Хувиараа бизнес эрхлэгч
Одоо эрхэлж буй ажил	Бигүхан ХХК-ийн Захирал

Лхагвасүрэнгийн Чулуунбаатар

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1982
Боловсрол	Дээд
Мэргэжил	Эдийн засагч
Эрхэлж байсан ажил	Хувиараа бизнес эрхлэгч
Одоо эрхэлж буй ажил	Хувиараа бизнес эрхлэгч

Мөнх-Эрдэнэнийн Ундрал

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1977
Боловсрол	Дээд
Мэргэжил	Менежер
Эрхэлж байсан ажил	✓ 2000-2001 “Нийтийн тээврийн зохицуулах газар” – Санхүүгийн хэлтсийн ажилтан ✓ 2003-2006 он “Ти-Эс-эйч трейд” ХХК – Менежер ✓ 2006-2009 он “Түгээмэл трейдинг” ХХК – Менежер
Одоо эрхэлж буй ажил	2023 онд Мерекс ХК-ийн Түр орлон гүйцэтгэгч захирал

Бадамжавын Цэрэнханд

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1981
Боловсрол	Дээд
Мэргэжил	Нягтлан бодогч
Эрхэлж байсан ажил	✓ 2006-2013 он “Арвис системс” ХХК– нягтлан бодогч ✓ 2013-2017 онд БНХАУ-д мастер хамгаалсан
Одоо эрхэлж буй ажил	Хайторк Монголиа ХХК – Нягтлан бодогч

Зоригтбаатарын Төрболд

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1995
Боловсрол	Дээд
Мэргэжил	Бизнесийн удирдлага
Эрхэлж байсан ажил	
Одоо эрхэлж буй ажил	2017 оноос хойш одоог хүртэл Стандарт инвестмент ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Алтанзүрхний Санчир

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1981
Боловсрол	Дээд
Мэргэжил	Гадаад харилцаа
Эрхэлж байсан ажил	✓ 2004-2010 Туушин ХХК-д Менежер ✓ 2010-2015 Моннис ХХК-д Менежер
Одоо эрхэлж буй ажил	2015 оноос одоог хүртэл Рэйл Экспресс ХХК-ийн захирал

ХАРААТ БУС ГИШҮҮД**Эрдэнэжүгдэрийн Эрдэнэсүх**

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1982
Боловсрол	Дээд
Мэргэжил	Мэдээллийн технологи
Эрхэлж байсан ажил	✓ 2008-2012 Интек ХХК-д Зөвлөх ✓ 2012-2016 Юнител ХХК-д Байгууллагын бизнесийн газар, Менежер ✓ 2016-2019 Оркин Монголиа ХХК-д Гүйцэтгэх захирал
Одоо эрхэлж буй ажил	2015 оноос одоог хүртэл Рэйл Экспресс ХХК-ийн захирал

Алтангэрэлийн Билгүүн

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1990
Боловсрол	Дээд
Мэргэжил	Зураглаач
Эрхэлж байсан ажил	✓ 2009-2011 он “Соёмбо” ТВ – Эфирийн найруулагч ✓ 2011-2012 он “С1” ТВ – Зураглаач ✓ 2012-2014 он “Ийгл” ТВ – Зураглаач ✓ 2014-2015 он “25” тв – Зураглаач ✓ 2016-2018 он “Торгоны зам сан” ХХК – Медиа албаны дарга ✓ 2018-2022 он “Бигүүхан” ХХК – Менежер
Одоо эрхэлж буй ажил	Хувиараа бизнес эрхлэгч

Ганболдын Чинхүсэл

Иргэний харъяалал	Монгол
Төрсөн он	1990
Боловсрол	Дээд
Мэргэжил	Бизнесийн удирдлага
Эрхэлж байсан ажил	
Одоо эрхэлж буй ажил	2011 оноос хойш Бигүүхан ХХК-ийн Албаны эрхлэгч

Үүгээр хэлэлцүүлэх асуудлыг товч та бүхэндээ танилцууллаа асуулт хариулт эхэллээ. Та бүхэн асуултаа асууна уу.

Асуулт: Хувьцаа эзэмшигч 3.Төрболд:

ТУЗ-ийн гишүүдийг хэрхэн яаж сонгосон бэ?

Хариулт: Г.Бямбабаяр:

ТУЗ-ийн ердийн гишүүдийг хувьцааны голлох байр суурь эзэлж буй хүмүүс буюу компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдээс санал болгож байна. Харин хараат бус гишүүдийг компаниараа ярилцаж байгаад санал болгож байна.

Асуулт: Хувьцаа эзэмшигч: 3.Төрболд:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд хийгдсэн эсэх, өнөөдрийн нөхцөл байдал ямаршуу байна.

Хариулт: М.Ундрал:

Миний бие энэ жил энэхүү компанийн Түр орлон гүйцэтгэгч захирлаар томилогдон ажиллаж байна. Одоогийн байдлаар санхүүгийн асуудал их байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд борлуулалтаа сайжруулахын тулд түүхий эдийн татан авалтыг хямдаар олох, түүхий эд түүний нөөцийг бүрдүүлэх, зардлыг хэмнэх зэргээр эрчимтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэ жил ганцхан манай үйлдвэр гэлтгүй улс даяар эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж борлуулалт тааруу жил болж байна. өнгөрсөн жилийн хувьд 22,000 м3 бетон зуурмаг борлуулан зохих хэмжээний ашиг олсон ба энэхүү ашгаас өр авлагын асуудлыг шийдвэрлэн ирсэн. Цаашдаа улам нэмэгдүүлэн санхүүгийн хямралаас гарах бүхий л аргыг ашиглан хамт олноороо дайчлан ажиллаж компанийн үйл ажиллагаа санхүүгийн хүнд байдлаас гарах зорилт тавин хичээнгүйлэн ажиллаж

байна. Өнөөдрийн байдлаар бид 4-5 байгууллага 2-3 хувь иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Асуулт: Хувьцаа эзэмшигч: З.Төрболд

Үйл явцыг хэвийн жигд болгохын тулд нэмэлт хөрөнгө татах уу?

Хариулт: Г.Бямбабаяр:

Энэ жилд хөрөнгө татахгүй учир нь авлага өглөгөө барагдуулах тал дээр түлхүү ажиллаж байгаа бөгөөд хэрэв зайлшгүй шаардлагаар татан төвлөрүүлэхээр бол хувьцаа эзэмшигчдэд урьдчилан мэдэгдэж, хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Г.Бямбабаяр : Өөр асуулт байна уу. Байхгүй бол Тооллогын комиссын дарга Д.Уянга санал хэрхэн явагдах талаар танилцуулна.

Д.Уянга: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал асуулгад кумулятив аргыг ашиглана. Энэ нь өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоогоо санал болгож байгаа ТУЗ-ийн гишүүний тоогоор үржүүлж гарсан дүнгээ тэдгээр гишүүдэд хувааж байрлуулахыг хэлнэ. ТУЗ-ийн гишүүд нь ердийн болон хараат гэсэн 2 ангилалтай байна. Ердийн гишүүд нь 6 байгаа учраас хувьцааны тоог 6-р үржүүлж гарсан дүнг 6 ердийн гишүүндээ хувааж тавина. Зөвхөн нэг хүнд нь бүгдийг нь тавьсан ч болно. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгохдоо мөн адил өөрийн эзэмшиж буй хувьцааг 3-р үржүүлж гарсан дүнг 3 хүндээ хуваана. Үүнд анхаарах зүйл нь хэрэв таны гишүүдэд хуваан байршуулсан саналын нийлбэр нь таны саналын тооноос хэтэрсэн тохиолдолд санал хүчингүй болно. ТУЗ-ийн зардлын санал нь ердийн буюу зөвшөөрсөн, татгалзсан, түтгэлзсэн гэсэн 3 сонголтоос сонгоно.

Г.Бямбабаяр: Санал хураалтын хуудас аваагүй хүн байна уу. байхгүй бол санал хураалтыг эхлүүлье. Саналын хуудсаа бөглөн саналын хайрцаганд хийнэ үү.

Г.Бямбабаяр: Санал хураалт явагдаж дууслаа. Дүнг тооллогын комисс танилцуулах хүртэл түр завсарлая.

20 минут завсарлав.

Г.Бямбабаяр: Та бүхэнд тооллогын комиссоос гарсан санал хураалтын дүнг танилцуулъя.

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах

Нийт хуралд оролцогчдын 100% саналаар баталсан байна.

2. Ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг батлах

Нийт хуралд оролцогчдын 100% саналаар баталсан байна.

3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Ердийн гишүүд: Г.Бямбабаяр 16.7 хувийн санал өгсөн байна

М.Ундрал 16.7 хувийн санал өгсөн байна

А.Санчир 16.7 хувийн санал өгсөн байна

З.Төрболд 16.7 хувийн санал өгсөн байна

Л.Чулуунбаатар 16.7 хувийн санал өгсөн байна

Б.Цэрэнханд 16.7 хувийн санал өгсөн байна

Хараат бус гишүүдэд: Э.Эрдэнэсүх 33.3 хувийн санал өгсөн байна

Г.Чинхүсэл 33.3 хувийн санал өгсөн байна

А.Билгүүн 33.3 хувийн санал өгсөн байна

Г.Бямбабаяр: Хурлын саналын хуудсыг тоолж, үр дүнг танилцуулсан Д.Уянгадаа баярлалаа. Хурлын танилцуулсан асуудал болон гарах тогтоолууд маань 100 хувийн саналуудаар батлагдаж гарлаа. Холбогдох хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор тус бүрээр гарч, тамгалаад, хүчин төгөлдөр болоод, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Хуралд ирж оролцсолн та бүгдэд баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг батлав.
3. ТУЗ-ийн гишүүдээр

а. Ердийн гишүүдэд:

- Г.Бямбабаяр
- М.Ундрал
- А.Санчир
- З.Төрболд
- Л.Чулуунбаатар
- Б.Цэрэнханд

б. Хараат бус гишүүдэд:

- Э.Эрдэнэсүх
- Г.Чинхүсэл
- а.Билгүүн нарыг сонгов.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Тэмдэглэлийг хянасан:



Д.Уянга

“Мерекс” ХК-ийн нарийн бичиг

Г.Бямбабаяр

ТУЗ-ийн дарга